



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 18/196

Мөрөн сум

“Хаврын бүх нийтээр мод тарих өдөр”-ийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд хаврын “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд хаврын “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн хүрээнд айл өрх бүрийг 10 мод тарих, албан байгууллага бүрийг өөрийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод тарихад уриалж, мод тарих газрыг урьдчилан бэлдэх, хамгаалалт усалгааг шийдвэрлэх зэрэг бэлтгэл ажлыг бүрэн хангасны үндсэн дээр мод тарих ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Аймгийн хэмжээнд таригдсан мод бутыг бүртгэж, паспортжуулах ажлыг зохион байгуулахыг сумын Засаг дарга нар, Сум дундын ойн ангийн дарга нар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд хаврын “Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангаж, тайлан мэдээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж ажиллахыг сум дундын ойн ангийн дарга нар, Байгаль орчин аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

5. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж, мэдээ мэдээлэл хүргэж ажиллахыг “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны ажлын хэсэгт даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Завиуулам-2023

6712010006